

2025 оны 9-р сарын 30-ны өдөр

Хэвлэл мэдээллийн мэдээлэл

Монгол Улсад EMS Global сан, 2025 оны 10 сар

EMS Global сан нь Австралийн ашгийн бус бие даасан байгууллага юм. Анх Австрали улсын Гриффитийн их сургуулийн дэмжлэгтэйгээр 2017 оноос үйл ажиллагаа эхлүүлж байсан бол одоо Австралийн Засгийн газрын санхүүжилтээр энэхүү сургалтыг зохион байгуулж байна. Бид засгийн газруудтай хамтран эмнэлэг хүртэлх яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ (Emergency medical service EMS)-г бэхжүүлэхийн төлөө ажилладаг.

Бидний гол зорилго нь сургалт болон системийн шинэчлэлээр дамжуулан эмнэлгээс гадна хүний амь аврах юм. Засгийн газар, эрүүл мэндийн яам, санхүүжилтийн байгууллага болон орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй шууд хамтран ажилласнаар нотолгоонд суурилсан стратегийн шинэчлэл, дэвшилтэт эмнэлзүйн боловсрол, иж бүрэн чадавх хөгжүүлэлтээр дамжуулан тогтвортой, орон нутагт өөрийн өмчлөлийн EMS-ийг байгуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

- Австрали, Их Британи, Канадын олон улсын яаралтай тусламжийн парамедик сургагчид
- Бүгд Монголын эмнэлэг хүртэлх яаралтай тусламжийг чадавхжуулахаар сайн дураар ажиллаж байна. Багийн бүрэлдэхүүнд эрчимт эмчилгээний парамедик, их сургуулийн багш нар багтсан
- Энэхүү сургалт Австралийн Элчин сайдын яамны Шууд тусламжийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна.

Энэ сургалт яагаад чухал вэ: Монгол Улсад жил бүр ойролцоогоор 7,000 зайлсхийж болохуйц нас баралт бүртгэгддэг. Эдгээрийн олонх нь түргэн шуурхай, чанартай яаралтай тусламжийн тусламжтайгаар урьдчилан сэргийлэх боломжтой. Хүчтэй EMS нь нас баралтыг бууруулж, олон нийтийн итгэлийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмждэг.

Сургалтын дэлгэрэнгүй

- **Байршил:** Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв
- **Огноо:**
 - 9-р сарын 30 – 10-р сарын 3 (эмч нар)
 - 10-р сарын 6 – 9 (жолооч, аврагч, гал сөнөөгч)
- **Оролцогчид:** 82 түргэн тусламжийн эмч, жолооч, аврагч, гал сөнөөгч



- **Сургалтын хамрах агуулга:** гэмтлийн тусламж, амьсгалын замын менежмент, зүрхний массаж/амилуулах суурь болон ахисэн шатны тусламж (CPR), багийн ажиллагаа, өвчтөнг аюулгүй тээвэрлэх гэх мэт өргөн хүрээний сэдэв хамарсан онол, дадлагын сургалт болно.

Хүлээгдэж буй үр дүн

- Түргэн тусламжийн эмч, жолооч нарын ур чадвар дээшлэх
- Өвчтөнүүд эмнэлэгт хүрэхээс өмнө аюулгүй, илүү үр дүнтэй тусламж авах
- Эрүүл мэндийн яаманд орчин үеийн үндэсний EMS системийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- 2024 оны 10-р сарын амжилттай сургалтын үргэлжлэл (оролцогчдын 95% нь “маш сайн” гэж үнэлсэн)

Удирдлага

- Төслийн үүсгэн байгуулагч, дарга – Др. Хамиш Маклин (Австрали)
- Гүйцэтгэх захирал / парамедик – Жо Акер (Канад / Австрали)
- Клиник ба үйл ажиллагааны захирал – Леон Барановски (Их Британи / Австрали)
- Монгол дахь захирал – Др.Н.Сувд